



## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн салбарын Их Британи Америк судлалын тэнхимээс зохион байгуулах “*Emerging Issues in Teaching English Language in Post-Covid Era (Ковидын дараах үеийн Англи хэл заахад тулгарч буй асуудлууд)*” сэдэвт эрдэм шинжилгээний ээлжит бага хуралд эрдэмтэн багш, судлаачид Та бүхнийг өргөнөөр оролцохыг урьж байна.

Жил бүр зохион байгуулдаг энэхүү хурлын зорилго нь их дээд сургуулийн Англи хэлний багш, судлаачид хоорондоо туршлага солилцох, тулгарч буй асуудлаа хэлэлцэх шийдэл хайх, цаашид хамтран ажиллах гүүр болоход оршдог.

**Хэзээ:** 2021 оны 12 дугаар сарын 25-ны 10 цаг

**Хаана:** МУИС-ийн Номын сангийн байр 302, 502 тоот хурлын өрөө

**Хэл:** Англи

**Илтгэлийн хугацаа:** 15 минут

Хуралд оролцогчид илтгэлийн хураангуйг **2021 оны 12 дугаар сарын 20-ны 21.00** цагаас өмнө Google Forms-р дараах мэдээллийг илгээнэ.

### I. Илтгэгчийн тухай мэдээлэл

1. Овог, нэр
2. Ажиллаж буй сургуулийн нэр, тэнхим, албан тушаал
3. Холбоо барих утасны дугаар
4. Хамтран илтгэл тавих багш/судлаачийн нэр
5. Илтгэлийн сэдэв

### II. Илтгэлийн хураангуй (Англиар)

- Илтгэлийн хураангуйг 250 үгэнд багтааж, Times New Roman фонт–оор, үсгийн өндөр 12pt, мөр хоорондын зай 1.5 –аар бичнэ.
- Судалгааны ажлын сэдвийг бүх үсгийг томоор, 14pt өндөртэйгээр, **Bold** болгосон байна.
- Судлаачдын нэрс, харьяа байгууллага, и-мэйл хаягийг бичих ба илтгэгчийн нэрийн доогуур зурсан байна.
- Хураангуйд судалгааны ажлын үндэслэл, арга зүй, үр дүн, дүгнэлтийг тусгасан байна.
- Хураангуй нь математик бичиглэл, график, зураг, хүснэгт, тодорхойлолт агуулаагүй байна.
- Хуралд оролцогчид бүртгэлээ доорх линкээр /Google Forms/ орж холбогдох мэдээллийг бөглөж бүртгэлээ баталгаажуулна.

### Эрдэм шинжилгээний илтгэлд тавигдах ерөнхий шаардлага:

1. Англи хэл заах аргазүй, орчуулга зүй, орон судлал, хэл шинжлэлийн чиглэлээр асуудал хөндсөн байх
2. Судалгааны арга зүйг баримталсан байх
3. Илтгэгчийн нэр, илтгэлийн сэдэв, и-мэйл хаяг, холбоо барих утсыг тодорхой бичих
4. Хурлын үеэр тавих илтгэлийг **ppt хэлбэрээр** бэлтгэх

Илтгэлээ тус тэнхимээс эрхлэн гаргадаг “Mongolian Journal of English Language and Culture Studies (ISSN 2410-1389)”-ийн шаардлагад нийцүүлэн 2022 оны 5 дугаар сард хэвлэгдэх No.12 дугаарт хэвлүүлэх боломжтой.

**Хураангуй хүлээн авах хугацаа:** 2021 оны 12 сарын 20-ны 21 цаг хүртэл

**Хүлээн авах хаяг:** <https://forms.gle/zaD1wRyvzR6zQ9cN9>

**Зохион байгуулагчтай холбоо барих и-мэйл хаяг:** [sgundsam@num.edu.mn](mailto:sgundsam@num.edu.mn)

**Лавлах утас:** 8919-4823

